## БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ 2022-2025 ОНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2024 ОНЫ БИЕЛЭЛТ

2025.01.06-ны өдөр | Баян-Өндөр сум

| Д/д | Хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ | Хугацаа | Хамрах хүрээ | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хүрсэн үр дүн, биелэлт | Хяналтын үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **3.1 Албан хаагчдын ажиллах орчин нөхцлийг сайжруулах зорилтын хүрээнд:** | | | | | | |
| 1. | 3.1.1.Албан хаагчдын албан тасалгааг шаардлага хангасан тавилга, тоног төхөөрөмж, компьютер, бусад дэвшилтэд техник, технологийн хэрэглээг нэмэгдүүлэх; | жилдээ | албан хаагчид | -А заалны 1 албан өрөөний шалыг пракетлах, цаас устгагч машин авах,<br>-Байгууллагын батлагдсан төсөв, бусад орлогын эх үүсвэрийг судлан хэрэгжүүлэх | -2024 онд спортын А, Б зааланд албан хаагчдын нөөц бололцоог түшиглэн 08-09-р саруудад спортын заал, албан өрөө, тасалгаа, коридорт урсгал засварын ажлыг үндсэн үйл ажиллагааны орлогоос төсвийг төвлөрүүлэн 25,4 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.<br>-А заалны 6 албан хаагчийн болон жижүүрийн өрөөнд 4,500,000 төгрөгийн тохижолт, засварын ажил хийж, ая тухтай ажиллах нөхцөлөөр хангасан.<br>-Шинээр томилогдсон 2 албан хаагчдыг 600,000 төгрөгийн 2ш офисс сандалаар хангасан байна.<br>Биелэлт 100% | 100% |
| 2. | 3.1.2.Байгууллагын дотоод үйл ажиллагаанд интернэт сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангах, | жилдээ | Ажлын цагаар ажиллаж байгаа ажилчид | Юнителийн Эрдэнэт салбартай гэрээ байгуулсан байна. | Албан хаагчдын өрөөнд интернэт сүлжээний утсан кабель, засвар үйлчилгээг тогтмол хийж 1,688,000 төгрөгийн зардал гаргаж, ажиллах хэвийн үйл ажиллагааг хангасан байна.<br>Биелэлт 100% | 100% |
| 3. | 3.1.3.Ажил үүрэг гүйцэтгэхэд шаардагдах хэвлэх хувилах тоног төхөөрөмжийн хор цэнэглэх засвар | жилдээ | албан тушаал-тангууд | Байгууллагын бичиг хэргийн зардалын төсвийн хүрээнд хэрэгжүүлэх | Албан ажлын чиглэлээр 16 албан хаагч албан хэрэгцээндээ шаардлагатай байгаа бичиг хэргийн материал 1,177,000 төгрөгийн хэрэгслээр хангагдсан байна. Байгууллагын бичиг | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээг тухай бүр хийх бичгийн хэрэгсэл бусад зүйлсээр хангах; | | | | хэргийн төсвийн зарцуулалт хэтрээгүй байна. Биелэлт 100% | |
| 4. | 3.1.4.Ажлын байрны орчин нөхцөл, цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах; (халаалт, гэрэлтүүлэг, өрөөний тохижилт, цахилгаан хангамжийн үйлчилгээ, гэх мэт) ; | жилдээ | Албан хаагчид | Хамтран ажиллах байгууллага, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулах | -Ажлын байрны эрүүл ахуй, ариун цэврийн нөхцлийг сайжруулахад үйлчлэгч нарт мэдлэг олгох, туршлага солилцуулах зорилгоор 3 үйлчлэгчийг сургалтад хамруулж, улирал бүр шинжилгээ хийлгэж ажилласан.<br>-Албан тасалгааны гэрэлтүүлэг, цахилгааны зөрчлийг арилгаж нийт 3,996,000 төгрөгийн засвар үйлчилгээ хийсэн байна.<br>Биелэлт 100% | 100% |
| 5. | 3.1.5.Албан үүргээ гүйцэтгэх үед албаны унаагаар хангагдах эсхүл гарсан зардалд нөхөх олговор олгох; | жилдээ | Албан хаагчид | Ажил үүргийн хуваарийг тухай бүр гаргасан байх | Хөдөлмөрийн тухай хууль, хамтын гэрээний заалтын хүрээнд албан ажлын шаардлагаар ажил үүрэг гүйцэтгэхэд нийт 6 албан хаагчдад 2,950,000 төгрөгийн бензин талоноор хангаг ажилласан байна.<br>Биелэлт 100% | 100% |
| 6. | 3.1.6.Албан үүргээ гүйцэтгэж байгаатай холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх, бэлгийн дарамт үзүүлэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас албан хаагч, түүний гэр бүлийн гишүүнийг хамгаалах арга хэмжээ авах; | жилдээ | Албан хаагчид | Албан хаагчдад сургалт зохион байгуулах, мэдлэг олгосон байна. | Холбогдох төрийн байгууллага, ҮЭХ-ноос зохион байгуулж буй хууль, дүрэм, журмын сургалтад албан хаагчдыг тухай бүр оролцуулж байна.<br>-Албан хаагчдад Хүний эрхийн салбар зөвлөлийн референт Ц.Батзаяагаас 09 дүгээр сард “Хүний эрх гэж юу вэ?” сургалтад 26 албан хаагч;<br>-Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсээс 12 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан "Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт"-ийн сургалтад 22 албан хаагч; | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -Аймгийн ХАБЭАЗ-өөс зохион байгуулсан “Хөдөлмөрийн эрхлэлтийн харилцаанд хөдөлмөрийн эрхийн маргаанаас урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтад 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр 2 албан хаагч;<br>Биелэлт 100% | |
| 7. | 3.1.7.Шинээр томилогдон ажиллаж байгаа албан хаагчдад зориулсан ажилд авах үеийн гарын авлага боловсруулах | жилдээ | Албан хаагчид | Гарын авлага боловсруулж хэвлэлийн аргаар хэвлэсэн байна. | Албан ажилд шинээр ажилд орж байгаа албан хаагчдад байгууллагын товч танилцуулга, үйл ажиллагаа, мэдээллийг багтаасан гарын авлагыг танилцуулан ажиллаж байна. Энэ онд нийт 6 албан хаагч ажилд орж гарсан байна.<br>Биелэлт 100% | 100% |
| **3.2.Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилтын хүрээнд:** | | | | | | |
| 8. | 3.2.1.Ажилтан албан хаагчдын бие бялдрыг чийрэгжүүлэх зорилгоор спортын А зааланд Лхагва гаригт 2 цагаар тоглох заалаар хангах, нийт албан хаагчдыг хамарсан уралдаан тэмцээн, биеийн тамир, спортын арга хэмжээг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулах; | жилдээ | Албан хаагчид | -Ажилчдын чийрэгжүүлэлтийн цагийг 7 хоногт 1 удаа 2 цагаар заалны хуваарь оруулна.<br>-Ажилчдыг багт хуваан спортын төрлүүдээр өрсөлдүүлэх удирдамжийг батална.<br>-Байгууллагаа төлөөлөн уралдаан, тэмцээнд багаар оролцох нөхцөлийг бүрдүүлнэ.<br>-Дулааны улиралд явган алхалтыг зохион байгуулна. | -Спортын А зааланд Лхагва гаригийн 16.00-18.00 цагийн хооронд албан хаагчдын бие бялдрыг чийрэгжүүлэх чөлөөт цагийг заалны хуваарь тусгуулж, оролцоог хангах талаар хяналт тавьж ажиллаж байна.<br>-30 албан хаагчийг 4 багт хувааж, 03, 04, 10 дугаар сард буюу 3 удаагийн тэмцээн, уралдааныг зохион байгуулсан байна.<br>Биелэлт 100% | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 9. | 3.2.3.Ажилчдын амрах таатай нөхцөлийг бүрдүүлж, Монгол орны үзэсгэлэнт газруудаар жил бүр 1 удаа аялуулах; | 09-10-р сард | Албан хаагчид | 1 удаа аялал зохион байгуулсан байна. | 2024 оны 08 дугаар сарын 01-06-ны өдрүүдэд Архангай аймагт зохион байгуулсан салбарын урлаг, спортын наадамд албан хаагчдыг оролцуулж, Архангай аймгийн түүхт газруудаар аялалыг зохион байгуулсан. Нийт 20 албан хаагч хамрагдсан байна.<br>Биелэлт 100% | 100% |
| 10. | 3.2.4.“Эрүүл агаар-эм”, “Цасны баяр” зэрэг идэвхитэй амралт, явган болон тойрон аялалыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулах; | 01, 05, 10-р сард | Албан хаагчид | -Цасны баяр, явган аялалын удирдамж, маршрут гарган 2-4 удаа амралтын өдрүүдээр зохион байгуулна.<br>-Ажилчдыг багт хуваан зохион байгуулах | Байгууллагаас 09 дүгээр сард зохион байгуулсан Эко явган аялал арга хэмжээнд албан хаагчдыг оролцуулсан. 18 албан хаагч хамрагдсан.<br>Биелэлт 100% | 100% |
| 11. | 3.2.5.Албан хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэг, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг жилд 1 удаа зохион байгуулж, албан хаагчдыг бүрэн хамруулах; | улиралд | холбогдох ажилчид | -Ажилтан албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэн зөв дүгнэж, журмын дагуу үр дүнгийн урамшууллыг олгосон байна. | 11 дүгээр сард аймгийн БОЭТ-тэй хамтран 26 албан хаагчийг 3 төрлийн шинжилгээнд хамруулж, 8 албан хаагчийг нэмэлт 2 шинжилгээнд хамруулсан байна.<br>Биелэлт 100% | 100% |
| | **3.3.Албан хаагчдад цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, тэтгэмж олгох, шагнаж урамшуулах ажлын хүрээнд:** | | | | | |
| 12. | 3.3.1.Холбогдох хууль, тогтоомжийн дагуу албан хаагчийн цалин болон нэмэгдлийг тухай бүр шинэчлэх, шаардлагатай төсвийг холбогдох дээд байгууллагад уламжилж, шийдвэрлүүлэх; | жилдээ | Албан хаагчид | Хууль, тогтоомжийн хүрээнд шаардагдах төсвийн тооцоог гаргаж, холбогдох байгууллагад санал хүсэлт хүргүүлэх | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолын 3, 9, 10, 11 дүгээр хавсралтын дагуу албан хаагчдын цалинг газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 08-ны Б/06 дугаар тушаалаар цалин хөлсийг шинэчлэн олгосон.<br>Мөн газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 21-ний Б/49 дүгээр тушаалаар | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | спортын албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг 20%-аар олгож эхэлсэн.<br>-10 дугаар сард хоол, унааны санхүүжилт нэмэгдсэнтэй холбогдуулан 1 өдрийн хоолны мөнгийг 10,000 төгрөг, унааны зардалыг 1,000 төгрөг, гэрээт харуулын хоолны зардалыг 1,500 төгрөг, унааны ззардалыг 1,000 төгрөг болгож нэмэгдүүлсэн байна.<br>Нийт 38,093,665 төгрөг зарцуулсан байна.<br>Биелэлт 100% | |
| 13. | 3.3.2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүнг улиралд 1 удаа, төрийн захиргааны албан хаагчийг хагас жилд 1 удаа тус тус холбогдох журмын дагуу үнэлж, албан тушаалын үндсэн цалингийн 40 хүртэл хувиар | жилдээ | Албан хаагчид | Нийт 25 албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг улиралд 1 удаа журмын дагуу дүгнэж, цалингийн төсвийн хүрээнд олгох | Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг улирал болгон дүгнэж, даргын 2024 оны Б/08, Б/31, Б/47 дугаар тушаалаар 70-аас дээш үнэлгээ авсан албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгосон байна. Үр дүнгийн урамшуулалд 19,900,000 төгрөг зарцуулсан.<br>Биелэлт 100% | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 14. | 3.3.3.Өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангалттай сайн биелүүлсэн төрийн үйлчилгээний ажилтан албан хаагчдад ур чадварын нэмэгдлийг тогтоосон журмын дагуу олгох; | жилдээ | Албан хаагчид | Нийт 22 албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг сар бүр дүгнэж, цалингийн төсвийн хүрээнд 8-аас доошгүй удаа олгох | Байгууллагын даргын тушаалаар 01, 03, 05, 06, 07, 08, 09 дүгээр саруудад төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэлийг 10-25%-аар олгосон байна. Ур чадварын нэмэгдлийг 32,400,000 төгрөг зарцуулсан.<br>Биелэлт 100% | 100% |
| 15. | 3.3.4.Албан хаагчдын илүү цагаар ажилласан нэмэгдэл хөлсийг Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу Засгийн газраас батлагдсан журмын дагуу тухай бүр тооцож олгох; | Тухай бүр | Албан хаагчид | Албан хаагчдын цагийн тооцооллыг тухай бүр баталгаажуулах | Жижүүрүүдэд гарааны гүйцэтгэлээр Б зааланд шөнийн цаг 198, илүү цаг 600, А зааланд шөнийн цаг 248, илүү цаг 664, наадмын талбайд шөнийн цаг 1192, илүү цаг 1424 цаг тус тус үүссэн байна. ҮЭХ-той байгуулсан хамтын гэрээний дагуу гишүүдэд шөнийн цагийн хөлсийг 1,3 дахин, илүү цагийн хөлсийг 1,8% дахин нэмэгдүүлэн олгож байна. Цалингийн сан хүрэлцэхгүй үед илүү цагийн хөлсийг ажлын 2 өдрөөр тооцон ээлжийн амралт дээр нэмж олгож байна. Мөн 7 хоногийн амралтын өдрүүдээр ажилласан албан хаагчдад тухайн сарын ажилласан цагийн 10%-тай тэнцэх илүү цагийн хөлсийг 3 удаа даргын тушаалаар олгосон байна. 4,744,000 төгрөг зарцуулсан.<br>Биелэлт 100% | 100% |
| 16. | 3.3.5.Ажил хавсран, хослон, эзгүй байгаа ажилтны ажлыг давхар гүйцэтгэсэн мөн хууль, тогтоомжоор зөвшөөрөгдсөн ажил, үүргийг хариуцан гүйцэтгэж байгаа бол албан | Тухай бүр | Албан хаагчид | Тухайн ажилтантай харилцан тохиролцож хавсран ажил үүрэг гүйцэтгүүлж, нэмэгдлийг олгох | 2024 оны 01 дүгээр сараас 09 дүгээр сар хүртэл мэргэжилтэн М.Ариун-Эрдэнэд нээлттэй мэдээллийн өгөгдөлийн сан хариуцсан ажил гүйцэтгэсний нэмэгдэл 20%-аар, ХАБЭА хариуцсан мэргэжилтэн Ө.Билэгсайхан, ЭБА-т хариуцсан ажлын нэмэгдэлийг архив, бичиг хэрэг, | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | тушаалын үндсэн цалингийн 20%-40% хүртэл нэмэгдэл хөлсийг олгох | | | | хүний нөөцийн ажилтан Ч.Болдцэцэг, сантехникч-цахилгаанчин Ж.Алтантогосд жижүүр албан тушаал хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлсийг 40%-аар нарт тус тус тооцон олгосон. “Биеийн тамир, спортын газрын бүтэц орон тоо батлах тухай” аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/382 дугаар захирамжаар 09 дүгээр сараас шинэ бүтэц зохион байгуулалтын дагуу албан хаагчдын нэмэгдэлд өөрчлөлт орж ХАБЭА хариуцсан мэргэжилтэн Ө.Билэгсайхан, ЭБА-т хариуцсан ажлын нэмэгдэлийг архив, бичиг хэрэг, хүний нөөцийн ажилтан Ч.Болдцэцэг, цахим сан хариуцсан мэргэжилтний албан үүргийг хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг мэргэжилтэн М.Ариун-Эрдэнэд, жижүүр албан тушаалыг хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг нярав Т.Золзаяа нарт нэмэгдэл хөлсийг 40%-аар олгож ажиллаж байна.<br>Биелэлт 100% | |
| 17. | 3.3.6.Жилийн эцсийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 98-100% хангаж, А үнэлэгдсэн бол мөнгөн урамшуулал олгох; | жилдээ | Албан хаагчид | Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг улирал бүр дүгнэх | 2023 оны санхүүгийн тайлангийн урамшууллыг нягтлан бодогч Ж.Нямжаргалд албан тушаалын сарын цалингийн 80%-аар буюу 1,096,800 төгрөг, байгууллагын дарга Д.Дэлгэрбаяр Засаг даргын захирамжаар байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийг 100% хангаж, албан тушаалын цалин 1,933,000 | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төгрөгийн урамшуулалд хамрагдсан байна.<br>Биелэлт 100% | |
| 18. | 3.3.7.Эрхэлсэн ажил албан тушаалын чиглэлээр мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан албан хаагчдад сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлэх зорилгоор 1 удаа 250,000 (хоёр зуун тавин мянга) төгрөг хүртэл олгох; | жилдээ | Албан хаагчид | Албан хаагчдын гаргасан хүсэлт, суралцаж байгаа тодорхойлолтыг үндэслэн олгох | Албан хаагчдын гаргасан хүсэлт ирээгүй байна. | - |
| 19. | 3.3.8.Хууль, тогтоомжоор олгогдсон мөнгөн урамшуулал, тэтгэмж, буцалтгүй тусламжийг байгууллагын төсөвт суулгуулж олгох | жилдээ | Албан хаагчид | Албан хаагчдын гаргасан хүсэлт, хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийг үндэслэн олгох | Байгууллагын 2024 оны төсөвт нийт 3,246,800 төгрөгийн төсвийг батлуулсан байна.<br>Биелэлт 100% | 100% |
| 20. | 3.3.9.Төрийн албан хаагчийн чадамжид тулгуурлан мерит зарчмаар ажлын байранд сэлгэх, шилжүүлэх, дэвшүүлэн ажиллуулах; | жилдээ | Албан хаагчид | хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийг үндэслэн ажиллуулах | Аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/382 дугаар захирамжаар манай байгууллагын бүтэц, орон тоо шинээр батлагдсан.<br>Шинэчлэгдсэн бүтэц, орон тоогоор төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэх албан тушаалын 2 орон тоо бүтцийн нэгжийн удирдах албан тушаал хэлтсийн даргын орон тоон дээр ахлах мэргэжилтэн Д.Одгэрэл, Э.Лхамсүрэнбаатар нарыг мерит зарчмаар дэвшүүлэн ажиллуулахаар шалгаруулалтад оруулах саналыг аймгийн ТАЗСЗ-д 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 01/122 дугаар албан бичгийг хүргүүлсэн.<br>Биелэлт 100% | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **3.4.Албан хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах зорилтын хүрээнд:** | | | | | | |
| 21. | 3.4.1.Албан хаагчдын эхнэр амаржсан бол ажлын 10 өдрийн, төрсөн үр хүүхэд нь шинэ хүүхэдтэй болсон ажилтанд ажлын 5 өдрийн цалинтай чөлөөг тухай бүр олгох; | Тухай бүр | Албан хаагчид | Албан хаагчдын гаргасан хүсэлт | Ахлах мэргэжилтэн Э.Лхамсүрэнбаатар нь 07 дугаар сард шинэ хүүхэдтэй болсон тул газрын даргын 2024 оны Б/24 дүгээр тушаалаар ажлын 10 өдөр цалинтай чөлөө олгосон байна. Биелэлт 100% | 100% |
| 22. | 3.4.2.Шинээр гэр бүл болсон залуу гэр бүлийн баярт мөчийг хуваалцан 200,000 (хоёр зуун мянга) төгрөг хүртэл дэмжлэг үзүүлэх; | Тухай бүр | Албан хаагчид | Албан хаагчдын гаргасан хүсэлт | Ахлах мэргэжилтэн Э.Лхамсүрэнбаатар 07 дугаар сард, нярав Э.Баасанням 09 дүгээр сард шинэ хүүхэдтэй болсон тул газрын даргын 2024 оны Б/26, Б/43 дугаар тушаалаар тус 200,000 төгрөг, нийт 400,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Биелэлт 100% | 100% |
| 23. | 3.4.3.Албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас албан хаагч, түүний гэр бүлийн гишүүнийг хамгаалах арга хэмжээ авах; | Тухай бүр | Албан хаагчид | Албан хаагчдын гаргасан хүсэлт | Албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас албан хаагч, түүний гэр бүлийн гишүүнийг хамгаалах арга хэмжээний талаар мэдээллийг тогтмол ажилчдад хүргэж ажилласан ба зөрчил, гомдолын мэдээлэл ирээгүй байна. Биелэлт 100% | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 24. | 3.4.4.Хамт олноо төлөөлөн аливаа уралдаан, тэмцээнд оролцож буй албан хаагчдад өдрийн хоолны мөнгийг 10,000 (арван мянга) төгрөгөөр тооцож дэмжлэг үзүүлэх ба эхний 3 байранд шалгарсан тохиолдолд амжилтыг нь урамшуулж 1 хоногийн цалинтай чөлөө олгох; | Тухай бүр | Албан хаагчид | Тэмцээн, уралдааны удирдамжийн дагуу оролцсон байна. | Архангай аймагт зохион байгуулагдсан Хангайн бүсийн спортын салбарын 4 төрөлт тэмцээнд оролцсон тамирчдын өдрийн хоол, байрны зардалд 600,000 төгрөг зарцуулж, ажлын 3 өдөр биеэр амруулсан байна. Нийт 12 албан хаагч хамрагдсан.<br>Биелэлт 100% | 100% |
| 25. | 3.4.5.Албан хаагч 1 сараас дээш хугацаагаар хүндээр өвдсөн, гэр бүлийн гишүүн нь (гэр бүлийн гишүүн гэдэгт төрсөн үр хүүхэд, эхнэр, нөхөр, төрсөн аав, ээж орно) өвчний улмаас хөдөлмөрийн чадваргүй болсон тохиолдолд эмнэлгийн байгууллагын тодорхойлолт, албан хаагчийн хүсэлтийг харгалзан 1 удаагийн буцалтгүй тусламж болгон 250,000 (хоёр зуун тавин мянга) төгрөг хүртэл дэмжлэг үзүүлэх, гэр бүлийн гишүүнээ асран хамгаалахад зориулан ажлын 10 өдрийн цалинтай чөлөө олгох; | Тухай бүр | Албан хаагчид | эмнэлгийн байгууллагын тодорхойлолт, албан хаагчийн хүсэлт | Ар гэрийн гачигдал, яаралтай ажил гарсан үед албан хаагчдад 1-2 өдрийн цалинтай чөлөөг тухай бүр олгож ажилласан. Нийт 28 албан хаагч дэмжлэг авсан байна.<br>Биелэлт 100% | 100% |
| 26. | 3.4.6.Жилийн эцэст албан хаагчдын ажлын үр дүнг үнэлж, дүгнэн | Жилийн эцэст | Албан хаагчид | Хамт олны 100%-ийн саналаар Тэргүүний ажилтан”-г, бусад | 2024 оны 07 дугаар сард салбарын тэргүүний ажилтан тэмдэгээр шагнагдсан мэргэжилтэн Б.Энхжаргал, | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагын “Тэргүүний ажилтан”-аар 1 хүн шалгаруулж, өргөмжлөл, 400,000 (дөрвөн зуун мянга) төгрөг хүртэл урамшуулах, орон нутгийн шагнал урамшуулал болон төрийн дээд шагналд тодорхойлох; | | | шагналд шаардлага хангасан албан хаагчдыг тухай бүр тодорхойлох | архив, бичиг хэрэг Ч.Болдцэцэг нарт даргын 2024 оны Б/27 дугаар тушаалаар тус 150,000 төгрөг, нийт 300,000 төгрөг олгосон байна. | |
| 27. | 3.4.7.Албан хаагчийн хүүхдээс олон улсын болон улсын чанартай уралдаан тэмцээн, олимпиадад оролцож байр эзэлсэн тохиолдолд 100,000 (нэг зуун мянга) төгрөг хүртэл урамшуулал олгох; | Тухай бүр | Албан хаагчид | Албан хаагчдын гаргасан хүсэлт, баримт бичгийг үндэслэх | Албан хаагчийн хүүхдээс олон улсын болон улсын чанартай уралдаан тэмцээн, олимпиадад оролцож байр эзэлсэн хүсэлт ирээгүй байна. | 100% |
| 28. | 3.4.8.Албан хаагчийг орон байрны нөхцлөө сайжруулах зорилгоор цалингийн зээлийн хүүг бууруулах асуудлыг тухай банкинд уламжлан хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллах; | Тухай бүр | Албан хаагчид | Хаан банктай байгуулах гэрээнд санал оруулах, 1,4% болгох | Хаан банктай 2024 оны гэрээг шинэчлэн батлуулж, албан хаагчдад тус байгууллагад хэрэгжиж буй хөнгөлттэй нөхцөлийг тусган цахимаар болон биеэр цалингийн зээл авах нөхцөлийг бүрдүүлсэн.<br>Биелэлт 100% | 100% |
| 29. | 3.4.9.Хүүхдийн баяр, шинэ жилийг тохиолдуулан албан хаагчдын хүүхдүүдийн дунд арга хэмжээ зохион байгуулах, урамшуулах (0-18 насны хүүхдүүдэд бэлэг өгөх); | Тухай бүр | Албан хаагчид | Жилд 2 удаа | 2024 оны 06 дугаар сарын хүүхдийн баяр, 12 дугаар сард шинэ жилийн баярыг тохиолдуулан албан хаагчдын хүүхдүүдэд бэлэг өгсөн.<br>Биелэлт 100% | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 30. | 3.4.10.Албан хаагчдын өрхийн амьжиргааг дээшлүүлэх, сайжруулах зорилгоор Эрдэнэт спорт амралтын хүрээлэнд 5 албан хаагчид павильон түрээслүүлэн гэрээ хийж худалдаа, үйлчилгээ эрхлэх зэрэг өрхийн орлогоо нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулахад нь дэмжлэг үзүүлэх; | Тухай бүр | Албан хаагчид | Албан хаагчдын гаргасан хүсэлт, баримт бичгийг үндэслэх | Эрдэнэт спорт амралтын хүрээлэнд 08 дугаар сарын аймгийн баяр наадмаар гэрээт харуул Л.Лхагвасүрэн, Ч.Эрдэнэболд нарт павильон түрээслүүлэн гэрээ хийж худалдаа, үйлчилгээ эрхлэх дэмжлэг үзүүлсэн. Биелэлт 100% | 100% |
| 31. | 3.4.11.Ажилтан албан хаагчдад өндөр үнэтэй шинжилгээ хийлгэх, эм тариа худалдан авахад зориулан эмнэлгийн бичгийг үндэслэн үнийн дүнгийн 20% хүртэлх мөнгөн дэмжлэг үзүүлэх; | Тухай бүр | Албан хаагчид | Эмнэлгийн баримт бичгийг үндэслэн олгоно. | Хэрэгжээгүй. | 0% |
| 32. | 3.4.12.Бусад дэмжлэг, буцалтгүй тусламжийг Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад дүрэм, журмын дагуу хэрэгжүүлнэ. | Тухай бүр | Албан хаагчид | Албан хаагчдын гаргасан хүсэлт, баримт бичгийг үндэслэх | “Журам батлах, журмын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 83 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, “Төрийн захиргааны албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох тухай” Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/309 дүгээр тушаалыг үндэслэн дарга Д.Дэлгэрбаяр 9,539,484 төгрөг, ахлах мэргэжилтэн Д.Одгэрэл 6,680,058 | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төгрөг, ахлах мэргэжилтэн Э.Лхамсүрэнбаатар 6,680,058 төгрөг, нийт 22,899,600 төгрөгийн урамшуулал, дэмжлэг олгосон байна. Биелэлт 100% | |
| **3.5.Албан хаагчдын орон сууц, амьдрах орчин нөхцлийг сайжруулах зорилтын хүрээнд;** | | | | | | |
| 33. | 3.5.1.Аймгийн ИТХ-ын 2022 оны 13/05 дугаар тогтоолоор батлагдсан ”Төрийн албан хаагчдын хөгжлийн хөтөлбөр”-ийн хүрээнд шаардлага хангасан албан хаагчдын материалыг хүргүүлэх | Тухай бүр | Албан хаагчид | Хөтөлбөрийн 6.2.8 дахь заалтын дагуу материалыг бүрдүүлэх | аймгийн “Төрийн албан хаагчдын хөгжлийн дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 2024 оны арга хэмжээний төлөвлөгөөний 3 дугаар зорилтын 3.3 дахь хэсэгт тавигдах шаардлагыг ерөнхий нягтлан бодогч, аж ахуйн албаны дарга Ж.Нямжаргал нь хангаж Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/ дугаар захирамжаар 5,460,000 төгрөгийн санхүүжилтээр Бүгд Найрамдах Солонгос Ард Улсад 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрөөс 12 дугаар сарын 04-ний өдрийг дуустал ажлын 6 өдөр аялаад ирсэн.<br>2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2 дугаар зорилтын 2.4 дахь тавигдах шаардлагыг дагуу жижүүр Л.Болдбаатар, Б.Тэгшжаргал нар | 100% |
| 34. | 3.5.2.Гэр болон галлагаатай байшинд амьдардаг албан хаагчдад түлээ, нүүрс худалдан авахад нь зориулан 200,000 (хоёр зуун мянга) хүртэл мөнгөн дэмжлэг үзүүлэх; | 10 дугаар сард | Галлагаа-тай байранд амьдар-даг албан хаагчид | Албан хаагчдын судалгааг гаргах | Гэр болон галлагаатай байшинд амьдардаг албан хаагчдад түлээ, нүүрс худалдан авахад зориулан үйлчлэгч М.Цэрэнханд, гэрээт харуул Н.Дорждэрэм нарт газрын даргын 2024 оны Б/45 дугаар тушаалаар тус 180,000 төгрөг, нийт 360,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Биелэлт 100% | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **3.6.Албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, өөрийгээ хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд:** | | | | | | |
| 35. | 3.6.1.Байгууллагын захиалга болон өөрсдийн саналаар мэргэжил эзэмших, мэргэшлээ дээшлүүлэх, өөр мэргэжил эзэмшихээр сургалтад хамрагдвал холбогдох баримт бичгийг үндэслэн цалинтай чөлөө олгох; | Тухай бүр | Албан хаагчид | Албан хаагчдын гаргасан хүсэлт, сургуулийн тодорхойлолтын дагуу олгох | Улаанбаатар хотын Pinecone академид программ хангамжийн мэргэжлээр суралцаж байгаа мэргэжилтэн О.Мөнхзулд 2024 оны 05 дугаар сард ажлын 22 өдөр цахимаар, 09 дүгээр сард 2 сарын хугацаатай цалинтай, 12 дугаар сард 10 өдөр цалинтай чөлөө тус тус олгосон байна.<br>Биелэлт 100% | 100% |
| 36. | 3.6.2.Ажилтан албан хаагчдад богино хугацааны сургалтад хамрагдвал томилолтын зардал эсвэл сургалтын төлбөрийн зохих хэсгийг олгох; | Тухай бүр | Албан хаагчид | Албан хаагчдын гаргасан хүсэлт, сургуулийн тодорхойлолтын дагуу олгох | Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Биеийн тамир, спортын улсын хороонд зохион байгуулагдсан “Биеийн тамир, спорт-Тогтвортой хөгжил” олон улсын эрдэм шинжилгээний хуралд 2024 оны 05 дугаар сарын 26-28-ний өдрүүдэд оролцсон ахлах мэргэжилтэн Д.Одгэрэл, Э.Лхамсүрэнбаатар, мэргэжилтэн Ө.Билэгсайхан, Засгийн газрын тохируулагч агентлаг, Биеийн тамир, спортын улсын хорооны Спортын Анагаах ухаан, Эрдэм шинжилгээний Төвд 2024 оны 09 дүгээр сарын 08-09-ний өдрүүдэд зохион байгуулагдах “Спортын Анагаах Ухааны хөгжлийн чиг хандлага” сургалтад оролцсон ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн биеийн тамирын арга хэмжээ хариуцсан мэргэжилтэн Т.Уртнасан нарт албан томилолтын нөхөн олговорт 2,826,300 төгрөг олгосон байна.<br>Биелэлт 100% | 100% |
| 37. | 3.6.3.Ажилтан албан хаагч 3 сараас дээш 1 жил | Тухай бүр | Албан хаагчид | Албан хаагчдын гаргасан хүсэлт, | Албан хаагчдын гаргасан хүсэлт ирээгүй байна. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хүртэлх сургалтад хамрагдсан тохиолдолд ажлын байр, албан тушаалыг нь ажилтантай тохиролцон хэвээр хадгалах, цалингүй чөлөө олгох; | | | сургуулийн тодорхойлолтын дагуу олгох | | |
| | Нийт 37 арга хэмжээнээс 1 арга хэмжээ хэрэгжээгүй | | | | | биелэлтийн дундаж хувь-97,2% |